

ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА

Сургуулийн боловсролын суурийг дэмжих үйл явц

Токио Гакүгэй Их Сургуулийн харьяа
Сэтагая бага сургууль
Фүжита Рүмимарү

Хичээлийн судалгааны зорилго

- 1 . Хичээлийн чанар дээшлүүлэх
 - 2 . Багшийн сургалт
 - 3 . Судлагдахуун бүрийн агуулгын нарийвчилсан судалгаа ба ойлголт
 - 4 . Хүүхдээ ойлгох
- ※ Сургуулийн судалгаатай хамтран

1 . Хичээлийн чанар дээшлүүлэх

- Сургуулийн боловсролын анхны түвшин
- Хүүхэд боловсрон хөгжих газар
- Сонирхолтой сургууль
- Сайн хичээл болгох эрэлхийлэл

Багшийн мөнхийн тулгамдсан асуудал

2 . Багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт

1. Түвшин ахиулах

Жишээ: Асуулт тавих, Самбар төлөвлөлт, Дэвтэр хөтлөлт, Хүүхэдтэй ажиллах г.м

2. Хичээлийн бэлтгэл судалгаа

3. Үнэлгээ

◇ Самбар төлөвлөлтийн жишээ



Зураг

3 . Судлагдахуун бүрийн агуулгын нарийвчилсан судалгаа ба ойлголт

1. Боловсролын стандартын агуулгыг ойлгох
2. Хичээлд бодитоор тусгах (Хичээлийн хөтөлбөр боловсруулах)

4 . Хүүхдээ ойлгох

1. Бодит байдлыг судалж мэдэх, багш нар нэгдсэн ойлголттой байх
2. Хичээлийн үеэр хүүхдийнхээ хандлагыг сайтар мэдрэх, хүүхдүүдтэйгээ харьцах
→ Хичээлийн үнэлгээтэй холбогдоно
3. Хүүхдүүдийнхээ суралцахуйд багш дүн шинжилгээ хийх

Хичээлийн судалгааны бодит байдал

1. Хичээлийн судалгааг зохион байгуулах
2. Хичээл заах багш сонгох
3. Хичээлийн хөтөлбөр боловсруулах
4. Хичээл явуулах
5. Хичээлийн дараахи хэлэлцүүлэг
6. Хичээлийн судалгааны үр дүнг нэгтгэх

1.Хичээлийн судалгааг зохион байгуулах

- Хичээлийн судалгааны баг судалгааг төлөвлөн зохион байгуулах
- Нэг буюу хэд хэдэн жилийн турш зохион байгуулах судалгааны төлөвлөгөөнд тулгуурлах. Уг төлөвлөгөөний төслийг судалгаа хийх баг боловсруулан, багш нараар хүлээн зөвшөөрүүлсэн байх.

2. Хичээл заах багш сонгох

- Судалгааныхаа төлөвлөгөөнд үндэслэн хичээл заах багшийг сонгох.
- Бүх судлагдахууны бүрдлээс сонгох, анги бүлгээс сонгох зэргээр нөхцөл байдлаас хамааран янз бүр байна.

3. Хичээлийн хөтөлбөр боловсруулах

- Уг нь хичээл заах багш хичээлийн хөтөлбөрөө боловсруулах боловч, зарим тохиолдолд багаараа хамтран боловсруулдаг.
- Хөтөлбөрөө боловсруулж дуусгахаас өмнө хөтөлбөрөө хэлэлцүүлэх цаг гаргадаг. Шаардлагатай тохиолдолд, судалгааны баг дэмжлэг үзүүлдэг.
- Хичээлийн хөтөлбөрийн загвар нь чөлөөтэй байж болно.

4. Хичээл явуулах

- Зарчмын хувьд бүх багш нар хичээлд ажиглагчаар оролцоно.
- Сургагч багш болон хамтран судалгаа хийсэн багш нар хичээлд ажиглагчаар оролцох нь олонтаа.
- Ажиглагчид дор бүрнээ хичээлийн протокол хөтлөнө. Мөн, хичээлийн явцад видео бичлэг хийх явдал элбэг байдаг.

5. Хичээлийн дараахи хэлэлцүүлэг

- Хичээлийн дараа хэлэлцүүлэг зохион байгуулна..

◇ Хэлэлцүүлгийн хөтөлбөр /жишээ/

1. Санал хэлэх
 2. Хичээл заасан багш хичээлээ дүгнэж үг хэлэх
 3. Хэлэлцүүлэг
 4. Сургагч багш санал дүгнэлтээ хэлэх
 5. Дүгнэх
- ※ Хэлэлцүүлгийг өөр бусад аргаар ч зохион байгуулж болно.

6. Хичээлийн судалгааны үр дүнг НЭГТГЭХ

- Хичээл заасан багш хичээлээ дүгнэн, хэлэлцүүлгийн үед төрсөн сэтгэгдэлээ тайланд тусгана.
- Хичээл заасан багш хичээлийнхээ тухай дүгнэлтийг гаргана.
- Хичээлийн судалгааны баг хичээлийн үнэлгээ болон хэлэлцүүлгийг нэгтгэн дүгнэнэ.

◇ Хичээл зохион байгуулахад
чухалчилбал зохих зүйл

- **“Хүүхдийг нэн тэргүүнд тавих” сэтгэлгээ**

Ажиглалт хийснээр, хүүхэд хариултыг
өөрөө олж авна



Хичээлийг багшаас хүүхэд рүүгээ чиглэсэн буюу “Дээрээс доошоо” бус “Доороосоо дээшээ” чиглэсэн хичээл болгон өөрчлөх нь зүйтэй.

Жишээлбэл, байгалийн ухааны хичээлээр хүүхэд байгалийн юмс үзэгдэлүүдээс “Өөрөө асуудлыг ухаж ойлгон, шийдвэрлэх” гэсэн сургалтыг чухалчлан үзэх хэрэгтэй. Өөрөө хэлбэл, хүүхдийн хүсэл сонирхол болон бие даасан байдлыг нь хүндэтгэн үздэг сургалтыг төлөвлөх гэсэн үг юм.

2011оны үйл ажиллагааны тухай

- Жилд 15 удаа хичээлийн судалгаа зохион байгуулсан.
- 2012 оны 2-р сарын 4-нд, “Хичээлийн судалгааны тайлант уулзалт”-ыг зохион байгуулсан.
- Түүнчлэн, сургуульд суурилсан хичээлийн судалгаанаас тусдаа 12 удаа хичээлийн судалгаа хийсэн.

Токио Гакүгэй Их Сургуулийн
харьяа Сэтагая бага сургуулийн тэмдэглэлээс, 2011 он